



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**2018 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 он**

АГУУЛГА

Танилцуулга

Хуудас 2-3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлт
- МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт
- Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын
- Захирагч нарын 2018 онд хамтран ажиллах гэрээний биелэлт

Хуудас 4-4

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн биелэлт
- Засгийн газрын тогтоолын биелэлт
- Засгийн Газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Засгийн Газрын албан даалгаврын биелэлт
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын биелэлт
- Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын биелэлт
- Нийслэлийн Засаг даргаас 2018 оныг “Иргэдийн оролцоотой-Амьдрах орчинг сайжруулах жил” болгон зарласан ажлын биелэлт
- Зөвлөмжийн биелэлт

Хуудас 4-4

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ

Хуудас 4-19

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- Үйл ажиллагааны ил тод байдал хүснэгтээр
- Хүний нөөцийн ил тод байдал хүснэгтээр

Хуудас 19-20

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

- Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажил
- Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт
- Тайлангийн хурлын тэмдэглэл

Хуудас 20-21

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар байгуулагдан, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоог 12 хүнтэй үүнээс дарга -1 байхаар баталж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн -9 албан хаагчтайгаар анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/323 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоог нэмэгдүүлэн шинэчилж 18, үүнээс дарга 1 байхаар баталж, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хаируцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

2018 оны байдлаар тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/635 дугаар захирамжаар бүтэц орон тоог 18, үүнээс дарга, орлогч дарга, Захиргааны хэлтэс, Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс гэсэн нэгжтэй байхаар шинэчлэн баталж, Нийслэлийн Засаг даргын 2018 оны Жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай А/113 захирамжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-3/, түр ажилтан-1, нийт 22 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх замаар Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн соёл, бизнес болон дамжин өнгөрөх аялал жуулчлалын төв болох нөхцөлийг бүрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

АЛСЫН ХАРАА:

Аялал жуулчлалыг нийслэл хотын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэг бүхий салбар болгон хөгжүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.


ХАМРАХ ХҮРЭЭ:

Нийслэлийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагууд.

ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох
2. Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
3. Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх
4. Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах
5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
6. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
7. Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2018 оны байдлаар:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 зорилт, 6 заалт, 6 арга хэмжээний биелэлт 84%,
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 6 зорилт, 12 багц ажил 11 арга хэмжээний биелэлт 85.8 %
- МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%
- Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4-ийн Аялал жуулчлалын төв болно зорилтын 10 заалтын биелэлт 96%,
- Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн 13 заалтын 16 арга хэмжээний хэрэгжилт 97%,
- “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барив.

Нийт бодлогын баримт бичгийн хэрэгжилт 96.2%-тай байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

А. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2018 оны байдлаар:

- Ерөнхийлөгчийн зарлиг 1, 2 заалтын хэрэгжилт 100%,
- Улсын Их хурлын тогтоол 1, 1 заалтын хэрэгжилт 100%,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр 1, 1 заалтын хэрэгжилт 70%
- Засгийн газрын 5 тогтоолын 19 заалтын хэрэгжилт 97%
- Засгийн Газрын 4 хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын 5 заалтын хэрэгжилт 100%,
- Засгийн Газрын 2017 оны Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 01 дүгээр албан даалгаврын 11 заалтын хэрэгжилт 100%
- Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны Ажлын хэсэг байгуулах тухай /Аймаг, сум, дүүрэгт хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан, авилга, хээл хахуулийн хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан, ажлын байран дээр архидан согтуурсан, хадгалсан албан тушаалтан тушаалтантай/ тушаалын 13 заалтын бүрэн хэрэгжсэн 11, үнэлэх боломжгүй 1, нийт хэрэгжилт 100%
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2018 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 75%
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1 тогтоолын 3 заалтын бүрэн хэрэгжсэн 2, үнэлэх боломгүй 1, нийт хэрэгжилт 96%
- Нийслэлийн Засаг даргын 41 захирамжийн хэрэгжилт 100%
- Нийслэлийн Засаг даргын 1 албан даалгаврын 6 заалтын хэрэгжилт 100%

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 11 тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 94.3%-тай байна.

Б/. Нийслэлийн Засаг даргын 2018 оныг “Иргэдийн оролцоотой-Амьдрах орчинг сайжруулах жил” болгон зарлах тухай А/01 дугаар захирамжийн дагуу тус газар 3 зорилт 7 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний хэрэгжилт 2018 оны байдлаар 95.7%-тай ханган ажиллав.


ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

А/. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл

ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах, үйлчилгээг сайжруулах, шуурхай болгох зорилгоор албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үйлчилгээний хүсэлтийг түргэн, шуурхай хүргэх үүднээс уг асуудлыг хавсран хариуцдаг 1 ажилтан нэмж 2 болгон нэмэгдүүлж, аж ахуйн нэгж байгууллагаас зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл хүссэн хүсэлтийн дагуу ажлын хэсэг стандартын үзлэг шалгалтыг санал хүсэлт ирснээс хойш 10 хоногт багтаан шийдвэрлэхийг гол зорилтоо болгон ажиллав. ААНБ-уудаас ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын мэдээллийг даргын зөвлөлийн хурлаар тогтмол танилцуулж хяналт тавин, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. 2018 оны байдлаар стандартын шаардлага хангасан 441 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, стандартын шаардлага хангаагүй байгууллагад заавар зөвлөгөө өгч, 25 ААНБ-ын хүсэлтийг хүлээн авч судлан үзлэгт хамруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Стандартын шаардлага ханган үйл ажиллагаа явуулж зочид буудал, дэн буудлын тоон үзүүлэлт, сүүлийн 5 жилээр үзүүлбэл:



2015 оны 10 дугаар сараас Нийслэлийн хотын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-ын 7.2.1, 7.2.2-ын заалтын дагуу зочид буудал, амралтын газрын үйлчилгээний төлбөрөөс 1 хувийн албан татвар авдаг болсон. Олон улсад уг татварын орлогыг аялал жуулчлал, хотын дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулдаг байна.

Нийслэлийн хотын албан татварт аялал жуулчлалын салбарын орлогыг сүүлийн 4 жилээр үзүүлбэл:



2. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд:

➤ “Улаанбаатарын өвлийн наадам 2018” арга хэмжээ зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/42 дугаар захирамжийн дагуу 2018 оны 02-р сарын 03, 04-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Улаанбаатарын өвлийн наадам 2018” арга хэмжээг төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Урлагийн тоглолт, Ёхор хатирах, Мөсөн сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн болон сонирхогчийн тэмцээн, Регбигийн Улаанбаатарын цомын аварга шалгаруулах тэмцээн, үзүүлбэр, Цанын үйлчилгээ, цанын сонирхогчийн тэмцээн, Тэшүүрийн үзүүлбэр, тэшүүрийн үйлчилгээ, Гэр бүлийн буухиа болон олс таталтын тэмцээн, Мөсний шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн, сонирхогчийн тэмцээн, Мөсөн хананы авиралтын үзүүлбэр, сонирхогчийн тэмцээн, Сноубордын үзүүлбэр, мэргэжлийн тамирчдын тэмцээн, Паралайдингийн үзүүлбэр, Уулын авиралтын сургалт, Шатрын тэмцээн, Юкигассен буюу цасан бөмбөгөөр тоглох тоглоом, Нохой чарганы үйлчилгээ, Рони морь, тэмээ, цаа бугатай зураг авахуулах үйлчилгээ, 700 хүний цуйван сэгсрэх үзүүлбэр, халуун хоол унд, худалдааны үйлчилгээ зохион байгуулагдав. Наадамд нийт 55 846 500 төгрөгийг төсөвлөснөөс, хэмнэлт 67510 төгрөг болсон байна. Наадмыг 6000 орчим хүн үзэж сонирхсоны 100 орчим нь гадаадын иргэд байв. ОХУ-ын Эрхүү, Улаан-Үд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны нийт 20 төлөөлөгч уригдан оролцсон. “Дашваанжил”, “Сансар” супер маркет, “PC mall” ХХК хамтран ажиллаж, “Сансар” супер маркет, “PC mall” ХХК-ниуд нэрийн бүтээгдэхүүнээ иргэдэд сурталчлав. Уг наадмыг өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор анх 2009 оноос “Мөсөн шагайн тэмцээн” нэртэйгээр туул гол дээр мөсний шагайн тэмцээн, өвлийн дугуй, тэшүүрийн үзүүлбэр зэрэг арга хэмжээг зохион байгуулж байгаад 2014 оноос өргөжүүлэн Улаанбаатарын өвлийн наадам болгон өргөжүүлэв.

“Улаанбаатарын өвлийн наадам-2018” арга хэмжээ.



Мөсөн сур



Мөсөн шагай



Мөсөн шатар



Мөсөн хана, Сноубордын үзүүлбэр, тэмцээн, мөсөн шатар



Спортын тэмцээн, уралдаан, дүүргийн парад, Хоолны үзүүлбэр



Үндэсний хувцсны шалгаруулалт



➤ “Шөнийн гэрэлт гудамж”-ны нээлтийн ажиллагааг зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/347 дугаар захирамжийн дагуу 2018 оны 05-р сарын 11-ний өдөр нээж, 9 дүгээр сарын 16-ны өдөр хаалтын ажиллагааг зохион байгуулав. Энэ жилийн “Гэрэлт гудамж”-ны нээлтийн ажиллагааны үеэр Хайрын цоож зүүх хөшөөг нээв. Мөн 4 сарын турш батлагдсан хөтөлбөрийн дагуу арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “UB Jazz Club”-ийн тоглолт, “Их талын жазз” олон улсын наадам, Австри Монголын жазз хөгжмийн тоглолт, Шилдэг дижи нарын электро, бүжгийн фестивал, БНСУ-ын Соёлын өдрүүд зэрэг арга хэмжээг зохион байгуулав. Гэрэлт гудамжинд 2018 оны 9 сарын 1-ний байдлаар худалдаа, хоолны үйлчилгээний 75 аж ахуйн нэгж, 220 ажиллагсадтайгаар үйлчилгээ үзүүлж, 52 урлаг уран сайхны хамтлаг, 155 уран бүтээлчид оролцсон урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулсан байна.



➤ “Бүргэдчдийн баяр”-ыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор “Бүргэдийн баяр”-ыг БОАЖЯ, НЗДТГ, Баян-Өлгий аймгийн ЗДТГ, “Монголын Бүргэдчид” холбоо, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран Хан-Уул дүүргийн 8-р хороо, Богд хан уулын Жаргалантын аманд 2018 оны 3 сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулав. Арга хэмжээний үеэр Хамгийн сайхан үндэсний хувцастай, бүргэдтэй, морины тоноглолтой бүргэдчнийг шалгаруулах, Бүргэдчдийн үзүүлбэр, Казак үндэсний тоглоом Көкбар-Тулам буулалдах, Казак үндэсний тоглоом Газраас зоос шүүрэх-Ширга татах, Бүргэдчдийн парадыг тус тус зохион байгуулав. Уг арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 3300 орчим хүн үзэж сонирхсоны 500 орчим нь гадаадын иргэд байв.



➤ Талын салхи-2018 олон улсын мото наадам зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын А/506 дугаар захирамж, газрын даргын А/46 дугаарын тушаалын дагуу “Талын салхи-2018” олон улсын мото наадмыг 06-р сарын 09,10-ны өдрүүдэд Эрүүл мэндийн газар, нийслэлийн Цагдаагийн газар, Замын цагдаагийн алба, Налайх дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа. Гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах, аялал жуулчлалыг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилготой уг наадмыг өргөжүүлэн, олон улсын хэмжээнд анх удаа зохион байгуулав. Наадамд ОХУ-аас мото сонирхогчдын 13 холбооны 100, БНХАУ-аас 12 холбооны 60, Монгол улсаас 14 холбооны 400 орчим нийт гадаад дотоодын 39 холбоодын 560 мото сонирхогч тамирчид оролцлоо. Тус арга хэмжээний нээлт 2018 оны 06-р сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд эхэлж, 09,10-ны өдрүүдэд Тэрэлж дэх “Мондэ тур” амралтын газарт үргэлжлэн зохион байгуулагдаж, гадаад, дотоодын 5000 гаруй иргэн үзэж сонирхов. Тус арга хэмжээнд нийт 13.325.000 төгрөгийг зарцууллаа.



➤ “Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулав. - “Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/674 дүгээр захирамжийн дагуу Япон улсын Шёва холдингс компанийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын Хөнгөн атлетикийн холбоо, Монголын хэт холын марафон гүйлтийн холбоотой хамтран 8 дугаар сарын 19-ний өдөр 22 дахь жилдээ Богдхан уулын зүүн энгэр Шавартын аманд, 3,5,10,21 км болон “Богдхан ултра трейл 50км”-ийн зайд зохион байгуулав. Тэмцээнд 8 улсын 461 гаруй тамирчид оролцсоноос 120 нь гадаадын тамирчид оролцов.



- “Даншиг наадам-Хүрээ цам” арга хэмжээг зохион байгуулав.

Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор “Даншиг наадам-Хүрээ цам”-ыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/665 дугаар захирамжийн дагуу 08 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд Хүй долоон худагт Монголын Бурхны шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн Хүй долоон худагт зохион байгуулав. Наадмын үеэр 256 хүчит бөхийн барилдаан, Мандал өргөх ёслол, Жанлавцогзол ном унших, Их Очирваань шүтээний тахилга, урлагийн тоглолт, морьт сурын харвааны анхдугаар тэмцээн, лам нарын дунд Унзад, голч нарын тэмцээн, ном хаях, мэтгэлцэх тэмцээн, балин болон тосон урлалын тэмцээн, Хүрээ жахар цамын хурал хурах, дотоод цам харайх, үндэсний сурын үзүүлэх харваа, Их насны морьдын уралдаан, залбирал, ерөөл айлдах, жороо морины үзүүлбэр зэрэг арга хэмжээг зохион байгуулагдав. Наадмыг 10.000 гаруй иргэд, сүсэгтэн олон, жуулчид үзэж сонирхсон бөгөөд 2500 орчим нь гадаадын иргэд байлаа.



3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:

- Гэрлэх ёслолын ордонг хотын аяллын бүтээгдэхүүн болгов.

Гадаадын иргэд, жуулчдыг “Монгол хурим ёслол”-ын үйл ажиллагаа, хуримлах ёс заншилтай танилцах боломжийг нээж өгөх, монгол ёс заншлаа сурталчлан таниулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-тай хамтарч ажиллах Санамж бичгийг 2017 оны 05 сарын 15-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах төлөвлөгөө баталж өнгөрсөн 2017 онд “Монгол хурим ёслол”-ын үйл ажиллагаа, хуримлах ёс заншил, үнийн талаар танилцуулга англи монгол хэл дээр хэвлүүлэн аялал жуулчлалын үзэсгэлэн арга хэмжээний үеэр тарааж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг аялал жуулчлалын компаниудын хөтөлбөрт оруулах ажлуудыг хийв. 2017 онд гадаадын 25 аялагч жуулчдад “Монгол хурим ёслол”-ын үйл ажиллагаа, хуримлах ёс заншилтай танилцуулж, ажилласан ба жуулчид үйлчилгээний талаар сэтгэл хангалуун байсан байна. 2018 онд уг бүтээгдэхүүн үйлчилгээг үргэлжлүүлэх, “Их өргөө” ёслол хүндэтгэлийн гэрийг зуны улиралд гадаадын иргэд, жуулчдад сурталчлах, монгол гэрийн уран нарийн хийц, бэлгэдлийн тайлбар мэдээллийг англи хэл дээр хэвлүүлэн гаргах, морин хуурын аялгуу, гэрэл зураг авахуулах зэрэг үйлчилгээг шинээр нэмж сурталчлан ажиллаж байна.

- “Улаанбаатар брэнд лого” хэрэглэх ашиглах журмын төсөл боловсруулж байна. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 сарын 03-ны өдрийн “Уралдаан зарлах тухай” А/497 захирамжийн дагуу Улаанбаатар хотын брэндийг бий болгох зорилготой “Улаанбаатар брэнд лого” шалгаруулах уралдааныг 2017 онд батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж 9 оролцогчийн 13 бүтээлийг хүлээн шалгаруулав. Бүтээлийг шалгаруулахдаа Улаанбаатар хотын дүр төрхийг илэрхийлсэн бичвэр үсэгтэй, дүрс зурмалтай, зургийн хэмжээ /Dimension/ хамгийн багадаа 600px X 600px буюу 6 см x 6 см, зургийн нягтаршил /Image Resolution/ 600 pixels x 600 pixels хэмжээнээс дээш үзүүлэлттэй, бүтээлийн эх файлыг .ai, .psd Adobe Photoshop, Adobe Illustrator програм дээр бэлтгэсэн, олон төрлөөр ашиглаж болох өнгөний сонголт брэндбүүк танилцуулгатай ирүүлсэн иргэн Б.Яруусайхан, Т.Эрдэнэтуяа, Г.Баттогтох нарын бүтээлийг шалгаруулж, зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах гэрээ байгуулсан. Бүтээлийг цаашид Улаанбаатар хотыг сурталчлан брэндинг хийх зорилгоор “Улаанбаатар брэнд лого”-г хэрэглэх ашиглах журмын төсөл боловсруулж байна.

- “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармаг зохион байгуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны А/26 дугаар тушаалын дагуу 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр нийслэлийн Улаанбаатар чуулгын байранд “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармаг зохион байгуулав. Хөдөлмөрийн яармагт Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар 1000 гаруй

ажлын байр, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 байгууллага 500 гаруй нээлттэй ажлын байр нийт 1500 ажлын байр зарлаж, арга хэмжээг 1000 гаруй хүн сонирхож, 1100 хүн анкет бөглөн, ажлын ярилцлага өгснөөс 160 хүн түр болон байнгын ажлын байртай болсон байна. Уг арга хэмжээг 2013 оноос эхлэн төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж байна. Цаашид оролцогчдын тоо, салбарын ажлын байрны тоог нэмэгдүүлэхэд гол зорилтоо болгон ажиллана.



➤ “Улаанбаатар аялал жуулчлалын үзэсгэлэн” зохион байгуулав. “Улаанбаатар” аялал жуулчлалын үзэсгэлэнг 06 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулав. Үзэсгэлэнд БНХАУ-д улсаас 16 байгууллага, аж ахуйн нэгж, Монгол Улсад суугаа 4 элчин сайдын яам, 8 аймгийн аялал жуулчлалын газар, 3 тур оператор компани болон хот орчимд үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, сувиллын газар, аяллын бусад үйлчилгээ үзүүлдэг нийт 120 гаруй байгууллага оролцов. Арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ажиллав.

➤ “Төр хурхын амнаас-Цэцээ гүн” хүртэлх явган аяллын замыг тохижуулав. Явган аяллын чиглэл, тохижуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/505 дугаар захирамжийн дагуу Богдхан уулын “Төр хурх-Цэцээ гүн” чиглэлийн 8.5 км явган аяллын замд зүг заасан тэмдэглэгээ 28 ш, шонгүй тэмдэглэгээ 80 ш, сүүдрэвч 2-ыг шинээр, 3 сүүдрэвч засч, сандал багануудыг сольсон, ширээтэй сандал 6 ш, сандал 5 ш, гүүр 1 ш, замын хашлага 4 хэсэг газар нийт 200 м, мэдээлэл бүхий самбар 1 ш, хаалганы хажууд 1 ш, ан амьтдын танилцуулга бүхий самбар 4 ш, төмөр самбар 2 ш, анхааруулах болон хориглох тэмдэг 6 ш байрлуулав. Ажлыг 9 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авч, Богдхан уулын Дархан цаазат хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөв.



Явган аяллын замыг тохижуулснаар Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амрах, зугаалах нөхцөл, боломжийг бүрдүүлж, аялагчдын тав тухыг хангаж таатай орчинг бүрдүүлэв.

➤ “Зайсан-Баруун ширээт” явган аяллын бүсэд ариун цэврийн байгууламж байгуулав. БОАЖЯ-тай хамтран Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр 2017-2020 онд хэрэгжих “Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг буруулах” жишиг төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Богд уулын Зайсангийн ам, Богд хан амралтын газарт аялал жуулчлалын чиглэлээр баригдсан 264 авто машины зогсоол орчимд нэг удаа 12 хүн зэрэг үйлчлүүлэх, гар угаах өрөө, бага насны хүүхэдтэй болон жирэмсэн эхчүүдийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоноглолтой нийтийн хэрэгцээнд ашиглах ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэг байгуулж ашиглалтад оруулахаар бэлэн болсон, газрын асуудал шүүхийн маргаантай байгаа тул хийгдэх боломжгүй байгаа. Тохижилтын ажил хийснээр аялагчдын тав тухыг хангаж, таатай орчинг бүрдүүлэх юм.

4. Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:

- “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барив.
- Гадаадын зочид, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, тэдгээрийг жилийн дөрвөн улиралд жигд, тэнцвэртэй хүлээн авах, аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрөл, арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “MICE” буюу албан болон бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах ажлыг БОАЖЯ-ны захиалгаар Үндэсний Аялал жуулчлалын байгууллага ТББ гүйцэтгэж байгаа. Үндэсний Аялал жуулчлалын байгууллага ТББ нь Монгол улсын албан болон бизнес аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал болон гадаад орнуудын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гадаад, дотоод зах зээл, хөгжүүлэх бодлого хөтөлбөр санал, дүгнэлт, зөвлөмж хэсгээс бүрдсэн тайланг БОАЖЯ, НАЖГ-т ирүүлсэн. Тайланд санал өгөхөөр ажиллаж байна.
- Байгаль орчин Аялал жуулчлалын сайдаас өгсөн чиглэлийн дагуу тус яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартай хамтран Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043-2009, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927:2008 стандартуудыг шинэчлэн боловсрууллаа. Дээрх стандартуудыг 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Стандартчилал хэмжил зүйн газрын Аялал жуулчлалын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг холбогдох байгууллагуудаас санал авч, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллөөр хэлэлцүүлэн саналыг тусгав.

6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Гадаад сурталчилгааны маркетингийн төлөвлөгөө боловсруулав. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулан баталж, 2018 оны байдлаар төлөвлөгөөний хэрэгжилтийг 100%-тай ханган ажиллав. Мөн 2019 онд Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах маркетингийн төлөвлөгөөний төсөлд саналаа НЗДТГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлэв.
- Улаанбаатар хотыг гадаадад сурталчилж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Зүүн хойд Азийн бүс нутгийн болон бусад орнуудад зохиогддог олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагуудад оролцож, аялал жуулчлалын маркетинг сурталчилгаанд интернэт, нийгмийн сүлжээг ашиглан Улаанбаатар хотыг гадаадад сурталчлав. Үүнд:

1. ЕМИТТ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов.

Бүгд Найрамдах Турк улсын Истанбул хотод 2018 оны 01 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ЕМИТТ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран оролцож эх орноо сурталчлав. Үзэсгэлэнгийн үеэр турк хэл дээр Улаанбаатар хотын тухай сэтгүүл 1000ш, Улаанбаатар хотын газрын зураг 100ш, Улаанбаатар хотын хөтөч ном 100 ширхгийг тараан, Улаанбаатар хотын талаар мэдээлэл өгч ажиллав. Үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагддаг уулзалт, форумд тус газрын дарга Д.Батсүх оролцов. Үзэсгэлэнд 85 орны 1.065 аялал жуулчлалын байгууллагууд, 106 орны 600 орчим аяллын бөөний худалдаа эрхэлдэг агентлагууд оролцож, 6.047 бизнес уулзалтууд болов. Үзэсгэлэнд Монгол улс анх удаа төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоотой хамтран нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон. 2018 онд Турк улсаас Монгол улсад ирсэн жуулчдын тоо 2699 буюу өмнөх онтой харьцуулахад +18.8%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 81 гаруй сая хүн амтай Турк улсаас манай улсад зөвхөн 2699 хүн жуулчилсан байна. Энэ нь агаарын тээврээр шууд нислэгтэй, 2 орны иргэд

харилцан визгүй зорчдог хөнгөлөлттэй тул цаашид Турк улсаас буюу түүний хил залгаа орнууд болон Европоос дамжин ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ.

Үзэсгэлэнгийн үеэр



2. “Ай Ти Би Берлин-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод 2018 оны 03 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай Ти Би Берлин-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд БОАЖЯ, НЗДТГ болон мэргэжлийн холбоод, 8 тур оператор компани, Улаанбаатар Чуулгын 5 уран бүтээлчдийн хамт оролцов. Үзэсгэлэнгийн үеэр А4 хэмжээтэй герман хэл дээрх Улаанбаатар сэтгүүлийг 1300 ширхэг, Улаанбаатар хотын газрын зураг 100 ширхэг, Улаанбаатар хотын хөтөч ном 100 ширхгийг тараан Улаанбаатар хотыг сурталчлан танилцууллаа. Үзэсгэлэнд 186 орны 10.000 гаруй аялал жуулчлалын бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож, 170.000 хүн ирж үзэж сонирхсон байна. Голлох зах зээлийн орноор авч үзвэл Герман улс эхний 7-д жагсдаг байна. 82 гаруй сая хүн амтай Герман улсын хувьд манай улсад зөвхөн 10822 орчим нь жуулчилдаг байна. Цаашид сурталчилгаа хийснээр шууд нислэгтэй, визний хөнгөлөлттэй тул Герман болон Европ улсаас дамжин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжтой юм.

3. “БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов.



Оросын Холбооны Улсын Эрхүү мужид 2018 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран оролцож Улаанбаатар хотоо сурталчилгааг хийв. Үзэсгэлэнгийн 2 дахь өдөр Нийслэлийн Аялал жуулчлалын газар Эрхүү мужийн Аялал жуулчлалын агентлагтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулав. Аялал жуулчлал өндөр хөгжсөн хотуудын аялал жуулчлалын зах зээлийн судалгаанаас үзэхэд голлох жуулчид нь хил залгаа орноос нь ирдэг байна. Улаанбаатар хот “Байкалтур” үзэсгэлэнд өмнө нь 2012 онд оролцож байсан бол 2017 онд оролцож, үндэсний онцлогийг харуулсан стенд, эвент арга хэмжээ зохион байгуулж, үзэгч, зочдын сонирхлыг татсан тул зохион байгуулагчийн шагнал “Золотая звезда” /Алтан Од/ цом, өргөмжлөлийг хүртсэн байна. Мөн 2016 онд Москва хотод болсон МИТТ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Москва хот дахь Улаанбаатар хотын төлөөлөгч сурталчилгаа хийж оролцож байсан. 2018 оны байдлаар ОХУ-аас ирэх жуулчдын тоо 129,094 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17%-иар өссөн үзүүлэлттэй байна. 146 гаруй сая хүн амтай ОХУ-аас манай улсад зөвхөн 129 мянга орчим хувь нь жуулчилдаг байна. Цаашид аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцох, 1960-1990 онд Монгол улсад ажиллаж, амьдарч, сурч, цэргийн алба хааж байсан иргэдэд зориулсан тусгай сонирхлын аяллын хөтөлбөр гаргах, зах зээлд нь тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, бий болгох, сурталчилгааг түлхүү хийх шаардлагатай байгаа. Шууд нислэг, галт тэрэг, 24 цагийн ажиллагаатай авто замаар 2 улсын иргэд харилцан визгүй зорчдог хөнгөлөлттэй тул ОХУ улс болон ОХУ улсаар дамжин ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжтой юм.

4. JATA үзэсгэлэнд оролцов.

Япон улсын Токио хотноо 2018 оны 9 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан JATA 2018 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл, Нийслэлийн Улаанбаатар Чуулгын уран бүтээлчид, Сумогын их аварга Асашорюу Дагвадорж нар хамтран эх орноо сурталчлан оролцлоо. Үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар хотыг сурталчлах 1500ш сэтгүүл тарааж, Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийн урлагын тоглолт, дэлгэцээр хотын аялал жуулчлалын сурталчилгаа болон “City bus tour” төслийн видео шторкийг үзүүлж, үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагддаг уулзалт форумд НАЖГ-ын дарга Д.Батсүх оролцов. Дэлхийд томоохонд тооцогдох тус үзэсгэлэнд энэ жил дэлхийн 136 улс орон, бүс нутгийн төлөөлөл, япон улсын 47 муж, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг 1.400 гаруй байгууллага, компани оролцож, нийт 200.000 гаруй хүн үзэж сонирхох байна. Үзэсгэлэнд оролцсоноор 2018 оны байдлаар ази, номхон далайн орнуудын жуулчдын тоо 269.615 буюу 14.1%-иар, Япон жуулчдын тоо 20.990 буюу -7.6%-иар буурсан үзүүлэлттэй байна. 127 сая гаруй хүн амтай Япон улсаас манай улсад зөвхөн 20 гаруй мянган хүн нь жуулчилдаг байна. Шууд нислэгтэй, визний хөнгөлөлттэй тул цаашид ази, номхон далайн орнууд болон Япон улсаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжтой юм.



Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцож Улаанбаатар хотыг сурталчлан ажилласнаар 2018 оны байдлаар Монгол улсад 529.370 жуулчин ирсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 11.01%-иар, салбарын орлого 569.542.966 ам доллар буюу 29.6%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Гадаад оронд зохион байгуулагддаг үзэсгэлэнд оролцож сурталчилгаа хийснээр Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлд эзлэх байр суурийг баталгаажуулах, сурталчлан таниулах, өрсөлдөх чадварыг сайжруулах, улмаар жуулчдын тоог нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

7. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд:

- Цагдаагийн газартай байгуулсан 2017-2020 онд хамтран ажиллах Санамж бичгийн дагуу гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, жуулчдад Монголын түүх соёл, нийслэл хотоо сурталчлах зорилгоор жуулчид ихээр зорчдог газруудад 36 оюутан цагдааг 2018 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулж байна. Энэхүү арга хэмжээ нь 2014 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд сүүлийн 4 жилд тус арга хэмжээний үеэр гадаадын жуулчидтай холбоотой хэрэг зөрчил буурч байгаа.
- Гадаад, дотоодын жуулчдын аюулгүй зорчих байдлыг хангах, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байранд аялал жуулчлалын төв мэдээлэл, сурталчилгааны төв, 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Төв шууданд мэдээлэл, сурталчилгааны төв салбар 1, 5 дугаар сарын 09-ний өдрөөс Сөүлийн гудамжинд гэр жуулчны мэдээллийн төв салбар 2-ийг тус тус ажиллуулсан.
- Нийслэлийн Засаг даргын 2015 оны Улаанбаатар хотын автозамын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай А/469 дугаар захирамжийн дагуу 8-аас дээш хүний суудалтай жуулчин тээврийн хэрэгсэлд дугаарын хязгаарлалтгүй замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл олгох журам, гэрээг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны А/33 дугаар тушаалаар шинэчлэн баталж, 2018 оны байдлаар 500 гаруй жуулчин тээврийн хэрэгсэлд олгоод байна.

8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд:

- Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгтэй хамтран 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр төмөр замын зорчигч тээвэрлэлтийн 256 үйлчлэгчид хилийн бүсийн мөрдөгдөх дүрэм, журмын талаар мэдээлэл өгөх сургалт, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хот орчимд үйл ажиллагаа явуулдаг амралтын газар жуулчны баазуудад зориулсан байгаль орчны сургалт зохион байгуулж, 20 аж ахуйн нэгжийн менежер хамруулж, жуулчид ихээр зорчдог газруудад ажиллах 36 оюутан цагдаад Нийслэлийн Цагдаагийн газраас хууль эрх зүйн мэдлэг олгох, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, аюулгүй байдлын талаар 2 өдрийн сургалт, “Жуулчин” ХК, Трэвел Хаб Монголиа компанитай хамтран Хөтөч тайлбарлагчийн сургалт зохион байгуулж 46 хүнийг хамруулж, МХЕГ-ын Экспорт импорт хил хорио цээрийн хяналтын газар, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулан “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Код-4” сэдэвт сургалтыг 2018 оны 11-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, зочид буудал, жуулчны баазын 60 орчим хүн хамрагдав. 2018 оны байдлаар салбарын үйлчилгээний ажилтнуудад эрх зүйн мэдлэг олгох, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 6 удаагийн сургалтад нийт 736 хүнийг хамруулав.
- Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 4 жилийн хугацаатай хөтөлбөрийг боловсруулан газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар батлуулав. Хөтөлбөрийн хүрээнд 2 зорилт, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2018 оны төлөвлөгөө, албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг 96% ханган ажиллав.

9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- Оросын Холбооны Улсын Эрхүү мужид 2018 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/234 дүгээр захирамжийн дагуу тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн З.Оюуншүр, олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн Г.Азжаргал оролцож, үзэсгэлэнгийн үеэр 03 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн Аялал жуулчлалын газар Эрхүү мужийн Аялал жуулчлалын агентлагтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулав.

- 2017 оны 12 сарын 20-ны өдөр хамгийн том мэдээллийн сайт www.china.com.cn-тай хамтран ажиллах Санамж бичгийг БНХАУ-ын Бээжин хотноо байгуулсан. Санамж бичгийн дагуу Улаанбаатар Өвлийн наадам-2018 арга хэмжээ зохион байгуулагдсан талаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот болон Эрээн хотуудад “Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг” бизнесийн уулзалт арга хэмжээг зохион байгуулсан талаар Монгол Хятад орнууд аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг эхлүүлнэ гарчигтай мэдээллүүдийг нийтэлж Улаанбаатар хотыг сурталчилсан байна.
- Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/337 дугаар захирамжийн дагуу БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот болон Эрээн хотуудад 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд “Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг” бизнесийн уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Уг өдөрлөг арга хэмжээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Улаанбаатар чуулга, Улаанбаатар төмөр зам ХНН, Монгол наадам ОНӨҮГ болон аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчид зэргээс бүрдсэн 75 хүний бүрэлдэхүүн аялал жуулчлал болон урлаг соёлыг сурталчлах бизнес уулзалт арга зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын төр болон хувийн хэвшлийнхэн цаашдын хамтын ажиллагааны санамж бичиг болон гэрээнд гарын үсэг зурж хамтын ажиллагааг өргөжүүлэв. Хоёр өдөр зохион байгуулагдсан бизнес уулзалт арга хэмжээнд хоёр орны нийт 25 аж ахуй нэгжүүд оролцлоо.
- Улаанбаатар хоттой Ах дүү болон найрамдалт харилцаат Хөх хот, Эрхүү, Намьянжү, Мияконожо хотуудтай сурагч солилцооны хөтөлбөрийг зохион байгуулах ажлын хүрээнд НЗДТГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран БНСУ-ын Намьянжү, Япон улсын Мияконожо хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, ОХУ-ын Эрхүү хотоос нийт 60 хүүхдийг 2018 оны 07 сарын 23-ны өдөр сурагч солилцооны хөтөлбөрт хамруулав.

- Монгол-Хятад-Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын III дугаар хуралдааныг зохион байгуулав.

Эдийн засгийн коридор байгуулах тухай Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын хэлэлцээрийн хүрээнд Монгол-Хятад-Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын III дугаар хуралдааныг 2018 оны 07 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд БОАЖЯ-тай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулав. Гурван улсын Аялал жуулчлалын сайд нарын анхдугаар хурал 2016 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод болж хуралдаанаар “Цайны зам олон улсын аялал жуулчлалын холбоо”-г байгуулсан. Харин 2017 онд ОХУ-ын Улаан-Үүд хотноо зохиогдож, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлсэн. Энэ удаагийн Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан хуралдаанаар талууд “Цайны зам” олон улсын хөтөлбөрийг эхлүүлж, дөрөвдөгч орны жуулчдад улс дамнасан аяллын бүтээгдэхүүн санал болгох, хуралдаанаас гарах үр дүнг бодитой байлгах үүднээс Их түмэн голын санаачлага төсөл, НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын БНХАУ дахь Тогтвортой аялал жуулчлалын тандан судалгааны төвийн удирдлагуудтай хамтран хэрэгжүүлэх төслүүдийг эрчимжүүлэх, жуулчдын аюулгүй байдал, тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх асуудлаар хэлэлцэв. Хуралд гадаад дотоодын 200 гаруй төлөөлөгч оролцов. Хуралдаан зохион байгуулснаар Цайны замыг дахин сэргээж гурван улсад зорчих жуулчдын тоог нэмэгдүүлэх, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол-Орос, Монгол-Хятадын агаарын тээврийн шинэ чиглэлүүдийг бий болгох, нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлуудыг хэлэлцсэн нь, улс орны эдийн засагт, хөрш орнуудын хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн арга хэмжээ болсон юм.



- Хятадын соёл, аялал жуулчлалын өдөрлөг
2018 оны 09 дүгээр сарын 05-09-ний өдрүүдэд “Хятад орныг танин мэдэх” соёл, аялал жуулчлалын өдрүүдийн арга хэмжээг хоёр улсын Элчин сайдын яам, Хятадын төрийн зөвлөлийн хэвлэл мэдээллийн алба болон Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Өдөрлөг арга хэмжээний хүрээнд ӨМӨЗО-ны муж хотуудын аялал жуулчлалын танилцуулах арга хэмжээ, уран хатгалмалч, уран дархан үзэсгэлэн,

урлаг уран сайхны тоглолт, кино өдөрлөг, хоёр улсын эмч нарын үнэгүй үзлэг оношлогоо, тэмцээн уралдаан зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулав.

➤ Японы соёл, аялал жуулчлалын өдөрлөг зохион байгуулав.

2018 оны 09 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд “Япон Соёлын Наадам-2018” арга хэмжээг БОАЖЯ, Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин Сайдын яам, Монгол Улс дахь Япон Улсын Элчин Сайдын яамдын дэмжлэгтэйгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Лэтс трэвел ХХК-тай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Японы соёл урлаг, гар урлал, хөгжөөнт наадгай, тэмцээн, уралдаан, бараа бүтээгдэхүүн, амтат хоол зэргийг олон нийтэд сурталчлан танилцуулсан ба Япон Улсаас 120 орчим урлаг соёл, бизнесийн байгууллагуудын төлөөлөгч нар хүрэлцэн ирж оролцлоо.

➤ Солонгосын соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг Улаанбаатар хотод зохион байгуулав.

Нийслэл Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зорилтын хүрээнд Солонгосын соёлын өдрүүд арга хэмжээг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/771 дүгээр захирамжийн дагуу Бүгд Найрамдах Солонгос улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран 2018 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд “Солонгосын соёлын өдрүүд” арга хэмжээг Сөүлийн гудамж дахь “Гэрэлт гудамж”-нд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Нийслэлийн Улаанбаатар чуулга, Жонон хамтлаг, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Бүгд Найрамдах Солонгос улсын дуучин Жон Ко, Jaebi хамтлагийн тоглолтууд, К-Pop дууг хэн сайн дуулах вэ? тэмцээн, Солонгос улс руу аялах сугалаа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Арга хэмжээг дотоод, гадаадын жуулчид, иргэд нийт 4000 гаруй хүн үзэж сонирхсон байна.

➤ “Берлин хотын өнөөгийн хөгжил” арга хэмжээг зохион байгуулав.

Аялал жуулчлалын “Натур тур” ХХК компани, “Берлин хотын Бранденбургийн нисэх онгоцны буудал” ХХК-тай хамтран “Берлин хотын өнөөгийн хөгжил” арга хэмжээг 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Новотел зочид буудалд зохион байгууллаа. Арга хэмжээнд БОАЖЯ, Гадаад хэргийн яам, ХБНГУ-аас МУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, МИАТ ХК, Хүннү эйр ХХК, Эйро Монголиа ХХК болон аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчидээс бүрдсэн 100 гаруй зочид, төлөөлөгчид оролцов. Арга хэмжээний үеэр МИАТ ХК болон Берлин-Бранденбургийн нисэх онгоцны буудал ХХК нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

10. Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгтэй хамтран 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр төмөр замын зорчигч тээвэрлэлтийн 256 үйлчлэгчид хилийн бүсийн мөрдөгдөх дүрэм, журмын талаар мэдээлэл өгөх сургалтыг, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хот орчимд үйл ажиллагаа явуулдаг амралтын газар жуулчны баазуудад зориулсан байгаль орчны сургалтад 20 аж ахуйн нэгжийн менежер, Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, жуулчдад Монголын түүх соёл, нийслэл хотоо сурталчлах зорилгоор жуулчид ихээр зорчдог газруудад ажиллах 36 оюутан цагдаа, “Жуулчин” ХК, Трэвел Хаб Монголиа компанитай хамтран Хөтөч тайлбарлагчийн сургалт зохион байгуулж 46 хүнийг хамруулж, сертификат олгов. МХЕГ-ын Экспорт импорт хил хорио цээрийн хяналтын газар, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулан “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Код-4” сэдэвт сургалтыг 2018 оны 11-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, зочид буудал, жуулчны баазын 60 орчим хүн, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох 5 хоногийн сургалтыг 10 дугаар сарын 15-19-нд зохион байгуулж 134 хүнийг, 2018 оны байдлаар салбарын үйлчилгээний ажилтнуудад эрх зүйн мэдлэг олгох, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 6 удаагийн сургалтад нийт 736 хүнийг хамруулав.





11. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах талаар:

➤ Сурталчилгааны материал хэвлүүлэв. А4 хэмжээтэй Улаанбаатар сэтгүүл англи хэл дээр 3000ш, Жуулчны хөтөч ном англи хэл дээр 1500ш, Улаанбаатар хотын газрын зураг 5000ш, 2018 онд зохиогдох эвент арга хэмжээний календарь 500ш, Улаанбаатарын өвлийн наадмын мэдээлэл А4 хэмжээтэй нугалбар 6000ш, Улаанбаатар үзэсгэлэнгийн мэдээлэл А4 хэмжээтэй нугалбар 1000ш, Бүгд Найрамдах Турк улсын Истанбул хотод зохион байгуулагдсан “ЕМИТТ” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр А4 хэмжээтэй Улаанбаатар сэтгүүл турк хэл дээр 1000ш, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод зохион байгуулагдсан “Ай Ти Би Берлин-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд А4 хэмжээтэй Улаанбаатар сэтгүүл герман хэл дээр 1500ш, Оросын Холбооны Улсын Эрхүү мужид зохион байгуулагдсан “Байкалтур-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд А4 хэмжээтэй Улаанбаатар сэтгүүл орос хэл дээр 1000ш, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот болон Эрээн хотуудад “Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг” бизнесийн уулзалт арга хэмжээний үеэр А4 хэмжээтэй Улаанбаатар сэтгүүл хятад хэл дээр 3000 ширхэг, нийт 18.500ш хэвлэмэл материалуудыг тарааж, гадаад дотоодын иргэдэд мэдээлэл өгч, Улаанбаатар хотыг сурталчлав.

12. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах талаар:

➤ Бүгд Найрамдах Турк улсын Истанбул хотод 2018 оны 01 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ЕМИТТ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монголын аялал жуулчлалын холбоо болон Ялгуун брэнд, "А Стар Монголия ХХК", "Аян Трэйвэл ХХК", "Баттур ХХК", "ДМД Монголия ХХК" –ийн төлөөллүүд, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод 2018 оны 03 дугаар сарын 07-11-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай Ти Би Берлин-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монголын аялал жуулчлалын холбоо, МИАТ ХК, аялал жуулчлалын 8 тур оператор компани, Оросын Холбооны Улсын Эрхүү мужид 2018 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Летс трэвел, Хөвсгөл Мон трэйвэл, Сити тоувэр хотел, Монголын дугуйн холбоо, Монголия Күэст, Грэйт Си тур, КОО Вэнс, Өнгөлөг гэр кэмп зэрэг байгууллагууд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот болон Эрээн хотод 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг” бизнесийн уулзалт арга хэмжээнд Нийслэлийн Улаанбаатар чуулгын 45 уран бүтээлч, Улаанбаатар төмөр зам ХНН, Монгол наадам ОНӨҮГ болон аялал жуулчлалын салбарын 25 аж ахуй нэгжийн төлөөлөл нийт 75 хүн оролцуулав. 2018 оны байдлаар 4 удаагийн гадаад оронд зохион байгуулагдсан уулзалт, үзэсгэлэн арга хэмжээнд аялал жуулчлалын салбарын нийт 100 орчим төлөөллүүдийг хамруулав.

13. Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар:

➤ Гадаад, дотоодын жуулчдын аюулгүй зорчих байдлыг хангах, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байранд аялал жуулчлалын төв мэдээлэл, сурталчилгааны төв, 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Төв шууданд мэдээлэл, сурталчилгааны төв салбар 1, 5 дугаар сарын 09-ний өдрөөс Сөүлийн гудамжинд Гэр мэдээллийн төв салбар 2-ийг тус тус ажиллуулж эхлэв. Мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн

мэдээллийн нэгдсэн санд нийслэл болон орон нутгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 403 тур оператор, зөвшөөрөлтэй 158 зочид буудал, 137 дэн буудал, 18 амралтын газар, 107 жуулчны бааз, 36 музей галлерей, 14 урлагын байгууллага, үзвэр үйлчилгээний газар, 4 номын дэлгүүр, 20 гаруй худалдааны төв, 128 түүх соёлын дурсгалын тайлбар мэдээлэл, ресторан, зоогийн газар, орон нутгийн аялал жуулчлалын байгууллагууд зэрэг 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, үзвэр, худалдаа, үйлчилгээний хуваарь, аялал жуулчлалын чиглэлээр болон бусад эвент арга хэмжээний мэдээ, мэдээлэл зэрэг 10.000 гаруй мэдээллийг бэлтгэж, шинэчлэн ажиллаж байна. Мөн БОАЖЯ-нд хийгдэж байгаа аялал жуулчлалын салбарын нэгдсэн мэдээллийн санд Улаанбаатар хот цэс үүсгэн тус газрын мэдээллийн санд байгаа мэдээллийг суулгав.



14. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах талаар:

➤ 2018 оны байдлаар Улаанбаатар Жуулчны мэдээлэл сурталчилгааны 3 төвөөр нийт 10200 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид үйлчлүүлэв. Жуулчдаас ирүүлсэн санал гомдлыг тухай бүрд нь холбогдох байгууллагуудад мэдээлж, тусалцаа үзүүлж ажиллав.

15. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх талаар:

➤ Нийслэлийн хэмжээнд болон орон нутгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн ажиллав. Тус газрын мэдээллийн санд 403 тур оператор, зөвшөөрөлтэй 144 зочид буудал, 142 дэн буудал, 10 амралтын газар, 107 жуулчны бааз, 36 музей галлерей, 14 урлагын байгууллага, үзвэр үйлчилгээний газар, 4 номын дэлгүүр, 20 гаруй худалдааны төв, 128 түүх соёлын дурсгалын тайлбар мэдээлэл, ресторан, зоогийн газар, орон нутгийн аялал жуулчлалын байгууллагууд зэрэг 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, 10.000 гаруй мэдээ, мэдээллийг бэлтгэж, шинэчлэн ажиллаж байна.

16. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх талаар:

➤ Эрхэлсэн ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн 9 дүүрэг, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг цаг тухайд түргэн шуурхай өгч ажиллаж байна.

17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах талаар:

А.Дотоодод

Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Гэрлэх Ёслолын ордон ОНӨААТҮГ, Бүргэдчдийн холбоо, Нийслэл Масс Медиа ХХК, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо, Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Дэлгэрэх тээх ХХК, Нүүдэлчин урлан галерей зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллав.

Б.Гадаадад

БНХАУ-ын Вэнхай хотын Вэндэн дүүргийн Аялал жуулчлалын газар, ОХУ-ын Эрхүү мужийн Аялал жуулчлалын агентлаг, БНХАУ-ын засгийн газрын албан ёсны мэдээллийн сувагтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллав.

18. Хууль тогтоожмид заасан бусад чиг үүргийн хүрээнд:

А. Зохион байгуулалтын чиглэлээр:

Чиг үүргийн хүрээнд дээд газрын шийдвэрээр ажлын хэсэгт ажиллав.

➤ Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/114 дүгээр захирамжаар батлагдсан “Монгол-Оросын санаачлага-2018” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсэг, А/183 дугаар захирамжаар батлагдсан Зүүн хойд Азийн хотын дарга нарын форум арга хэмжээний бэлтгэл ажлын хангах ажлын хэсэг, Монгол туурагтан соёлын наадам зохион байгуулах ажлын хэсэг, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2018 оны А/83 дугаар тушаалаар батлагдсан Шөнийн гудамж төслийн хүрээнд түр болон явуулын худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт тус газрын дарга Д.Батсүх оролцов. Мөн БОАЖ-ын сайдын 2018 оны А/68 дугаар тушаалаар Монгол, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын гуравдугаар уулзалтыг 2018 оны 07 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсэгт тус газрын дарга Д.Батсүх ажиллав. Мөн Улаанбаатар Төмөр Зам ХНН-ээс аялал жуулчлалын байгууллагуудтай зохион байгуулсан уулзалтад тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин оролцов.

➤ НИТХ-ын тэргүүлэгч Н.Батсүмбэрэлээс Нийслэлийн Засаг даргад ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 04/103 тоот албан бичгийн дагуу “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг дэмжих зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, ажиллах журмыг Нийслэлийн засаг даргын 2018 оны А/493 дугаар захирамжаар батлуулав.

➤ Аялал жуулчлалын улирал эхэлж буйтай холбогдуулан аялал жуулчлалын 145 аж ахуйн нэгж, амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд 2017 оны 9 дүгээр сард стандартын үзлэг шалгалтын мөрөөр хийсэн ажлын тайлан, мэдээ ирүүлэх болон Монголын улсын Засгийн газар, Нийслэлээс агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан хууль, эрх зүйн бодлого, шийдвэрийн хүрээнд хийж буй ажил, цаашид хийх ажлын чиглэл, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлаар НАЖГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/145 дугаар албан бичиг, зөвлөмжийг хүргүүлэв.

➤ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/864 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн орон зайн дундын мэдээллийн санд оруулах өгөгдөл мэдээллийг бэлтгэх ажил бүрэн хангагдаагүй нэмэлт координат байршлыг түүвэрлэх шаардлагатай байгаа тул Нийслэлийн Мэдээллийн технологийн газартай хамтран 2018 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар 24 элчин сайдын яамд, 2 консулын газар, 35 зочид буудлуудын мэдээллийг газар зүйн дундын мэдээллийн санд оруулсан байна.

➤ Гадаад хэл дээрх цахим хуудсыг шинэчлэв.

Гадаадын иргэд, жуулчдад зориулсан гадаад хэл дээрх цахим ашиглалтанд оруулав. “Датаком” ХХК-аас www.visitulaanbaatar.mn домайн хаяг худалдан авч, Нийслэлийн Мэдээлэл технологийн газраар шинэ вэб хост үүсгүүлж домайн хаягийн холболтыг хийв. www.visitulaanbaatar.mn цахим хуудас үндсэн 6 цэстэй, олон хэлний сонголттой, Улаанбаатар хотын үзвэр үйлчилгээ, жуулчдын зорин очих боломжтой газрууд, эвент арга хэмжээ, үндэсний соёл урлаг, хэрэгцээт мэдээ, мэдээлэл зэрэг олон төрлийн контентуудыг багтаав. Уг цахим хуудсан дах мэдээлэл нь англи хэл дээр байгаа бөгөөд цаашид нэмэлтээр 2 хэлний сонголт оруулав.

- “Улаанбаатар тусгай бүс” байгуулах ажлын хэсэгт ажиллав. “Улаанбаатар тусгай бүс” байгуулах ажлын хэсгийн анхны хурал 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан бөгөөд уг хурлаар тусгай бүсийн судалгааг шинэчилж, нэмэлт саналууд гаргах үүрэг өгсөн. Ажлын хэсгээс өгсөн үүргийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр судалгаа, саналыг ажлын хэсгийн хурал дээр танилцуулсан. 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр ажлын хэсэг дахин хуралдсан бөгөөд уг хурлаар байгууллагуудын саналыг нэгтгэж, “Улаанбаатар тусгай бүс”-ийг 3 цэгт байгуулах үндэслэл, тооцоо судалгааг НИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд өргөн барив.
- Авилгын эсрэг хууль тогтоомж, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор tourism.ub.gov.mn цахим хуудас, шилэн данс цэсийн мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн ажиллав.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус байгууллагын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар Нийслэлийн удирдлагын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу 15 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2018 оны байдлаар 100% биелэлттэй байна.
- Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг газрын хурлаар нийт албан хаагчдад тогтмол танилцуулж, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн хяналт тавин ажиллав. Тус газартай холбоотой үүрэг даалгаварын биелэлтийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Газрын хурлыг сард 1 удаа зохион байгуулж нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, байгууллагын төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, түүний үр дүн цаашид хийх ажлууд, аялал жуулчлалтай холбоотой сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг танилцуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар түүний хэрэгжилтийг байгууллагын дотоод сүлжээнд тогтмол байрлуулан ажиллав.
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг сараар төлөвлөж, хэрэгжилтийг сар тутам мэдээлэн, дээд газрын тогтоол шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлэв.
- МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 63 дугаар зарлиг, Ойн тухай хуулийн дагуу хаврын “Бүх нийтийн мод тарих өдөр”-өөр тус байгууллагын албан хаагчдаас нийт 85.000 төгрөгийг Ногоон байгууламжийн санд хандивлав.
- Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд тус газрын албан хаагчид оролцож Туул голын эрэг дагуу цэвэрлэгээ хийж том 25, жижиг 15 нийт 40 шуудай хог ачуулав.

Б. Цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар: Нийслэлийн Засаг даргын 2017 оны Хуваарь батлах тухай А/318 дугаар захирамжаар батлагдсан хуваарь, удирдамжийн дагуу Тус газрын удирдлагууд Багануур дүүргийн 1,2,3,4,5 дугаар хороонд ажиллаж, Нийслэлээс хэрэгжүүлж байгаа ажлыг сурталчилж, хороодын болон удаашралтай явагдаж байгаа 5-р хорооны “Их гүн” хэсэгт баригдаж байгаа 320 хүүхдийн бага сургуулийн барилгын ажлын явцтай танилцаж, тус дүүрэгт байрлах Чингэс хаантай холбоотой газар нутаг болох Бүрэг эргийг түүхэн аялал жуулчлалд хэрхэн татан оруулах, Бүрэг эрэгт байрлах эртний нүүдэлчдийн хөшөө дурсгал, 1600-аад онд халхын анхны 7-н хийдийн нэг зүүн хүрээ буюу өвгөн хийдийн туурь зэрэг түүхийн холбогдолтой газруудыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах талаар зөвлөгөө өгч, тус дүүрэгт зохион байгуулагдсан хөрөнгө оруулагчдын чуулганаар аялал жуулчлалын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулахад дэмжлэг үзүүлж ажиллав. Багануур дүүргийн төрийн албан хаагчдад “Үндэсний Бренд Хөгжүүлэлт ба Бид” сэдвээр сургалтыг Монгол улсын ерөнхий сайдын дэргэдэх Монголын Үндэсний брендийн зөвлөлийн ажлын албаны дарга Б.Батгэрэл, “Эерэг сэтгэлгээ” сэдвээр сургалтыг Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж 100 гаруй хүн хамрагдав. Багануур дүүргийн хороодод ойрын хугацаанд тулгамдаж байгаа ажил, цаашид хийх ажлын саналыг нэгтгэн НЗДТГ-г хүргүүлэв.

В. Шинээр санаачилсан ажил:

- “Сити тур” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/346 дугаар захирамжаар дэлхийн хотуудын жишгээр дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, нийслэл Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалын үзмэрүүд, хотын өнөөгийн хөгжилтэй танилцуулах зорилгоор 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд Сити тур төслийг хэрэгжүүлэв. Төслийг хэрэгжүүлэх 4 сар гаруй хугацаанд хотын төвийн маршрутаар 53, хотын төв-цонжин болдлог маршрутаар 32, тусгай хөтөлбөрөөр 14 аялал хийж нийт 99 удаагийн аялалд дотоодын 1164, гадаадын 454 хүнийг хамруулав.



Б/. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт. /Хавсралт 1./

В. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /КРИ-ЭЭР ҮНЭЛСЭН МЭДЭЭЛЭЛ

а/. Жуулчдад зориулан зохион байгуулж буй эвент арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж дотоод гадаадын иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байдал:

- 2018 онд гадаад, дотоодын иргэд жуулчдад зориулж 11 эвент арга хэмжээ зохион байгуулж 89.000 гадаад дотоодын иргэд, жуулчид хамрагдлаа. Энэ нь өмнөх онтой харьцуулахад эвент арга хэмжээний тоог 55%-иар, оролцогчдын тоог 59%-иар тус тус нэмэгдүүлэв.

б/. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг оновчтой зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход уг үзэсгэлэнг үзэж сонирхсон хүмүүсийн тооны нэмэгдсэн байдал:

- Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын 4 үзэсгэлэнд оролцож, давхардсан тоогоор 410 орны 13.506 байгууллага оролцож, 441.716 хүн үзэж сонирхсон нь өмнөх онтой харьцуулахад оролцсон үзэсгэлэнгийн тоог 1-ээр нэмэгдүүлж, давхардсан тоогоор оролцсон байгууллагын тоо 1976-аар, оролцсон орны тоо 96-аар, үзэж сонирхсон хүмүүсийн тоо 80.139-өөр тус тус нэмэгдсэн байна.

в/. Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулсан байдал:

- Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулахаар 2018 онд 3 ажил төлөвлөснөөс Богдхан уулын Төрхурх-Цэцээ гүн чиглэлийн явган аяллын 8.5 км замыг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийг тохижуулах 1 ажил хийгдсэн. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 03 сарын 01-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/179 дугаар захирамжаар Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох зорилтын хүрээнд зохион байгуулах арга хэмжээний жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад тохижилтын 2 ажил ороогүй бөгөөд санхүүжилт батлагдаагүй учир тохижилтын ажлыг хийх боломжгүй болсон.

Шалгуур үзүүлэлтийг гаргахдаа тухай жилд зохион байгуулсан ажлын судалгаанд үндэслэн, өмнөх онтой харьцуулан тооцож гаргав. Судалгааг хавсаргав. /Хавсралт 3./

Г. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах, санал хүсэлт ирснээс хойш 9 хоногт багтаан шийдвэрлэх талаар заалтыг нийт ажилтнуудын үр дүнгийн гэрээнд тусгаж, байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг тус газрын даргын зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлээр архив бичиг хэргийн эрхлэгчид үүрэг болгосон. 2018 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 14 өргөдөл, гомдол ирсэн нь 3 албан тушаалтанд хуваарилагдаж, хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд судалж байгаа болон хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй болно. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар тутамд тайлан гаргаж газрын дэргэдэх даргын зөвлөлийн хурлаар танилцуулж байна. Ирсэн өргөдлийн 80%-ийг хүний нөөцийн чиглэлээр 10%-ийг зочид буудал, үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой, 5%-ийг хамтран ажиллах, 5%-ийг дэмжлэг хүссэн өргөдөл эзэлж байна. Ирсэн өргөдөл, гомдлыг 100% хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна.

Үзүүлэлт	2017.01.02-12.31		2018.01.02-12.31	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Ирсэн өргөдлийн тоо	29	100%	30	100%

Д. БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ

2018 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг 3 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, Үнэлгээний хороонд НАЖГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/32 дугаар тушаалаар иргэн Д.Энхбатыг "Сити тур төслийн аудио тайлбарын төхөөрөмж нийлүүлэх" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны гишүүнээр, 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/47 дугаар тушаалаар иргэн Р.Дуламжавыг "Явган аяллын зам тохижуулах" ажлын Үнэлгээний хорооны гишүүнээр, 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/70 дугаар тушаалаар иргэн Р.Дуламжавыг "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчин хүлээж авах зориулалтын байр, зочид буудлуудыг зочны бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" Үнэлгээний хорооны гишүүнээр тус тус томилон ажиллуулсан.

Е. НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНД ТАЙЛАН МЭДЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны Журам батлах тухай 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны Журам батлах тухай А/335 дугаар захирамжийн дагуу байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт албан тоотоор НЗДТГ-ын ХШҮХ-т, тайлан мэдээг monitoring.ub.gov.mn сайтад байршуулж ажиллав. Мөн байгууллагын үйл ажиллагааны сарын тайлан, төлөвлөгөөг сар бүрийн дараа сарын 05-ны дотор цаг хугацаанд нь цаасаар НЗДТГ-ын ХШҮХ-т, цахимаар monitoring@ulaanbaatar.mn сайтад байршуулан ажиллав.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайланг хавсаргав. /Хавсралт 2./

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

А/. Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:

Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх үүднээс 12 төр болон төрийн бус гадаад, дотоодын

байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 70 хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллав.

Б/. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаарх:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, стандартын шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон ажиллаж байна. 2018 оны байдлаар тус газарт Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 07 дугаартай албан бичгийн дагуу иргэн Ж.Болдбаатарын "Сити" дэн буудал, нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын 08/52 дугаартай албан бичгийн дагуу Хангарьд хангал ХХК-ний "Фокус", иргэн Т.Энэбишийн "Од", иргэн Х.Болормаагийн "Тайга", иргэн Д.Наранзулын "Зүүм" дэн буудлуудын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны А/06, А/36 дугаар тушаалаар хүчингүй болгов.

В/. Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт:

Цаашид:

-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Гадаад харилцааны яамнаас санхүүжилтийн дэмжлэг авч ажиллах шаардлагатай,

-БОАЖЯ, ГХЯ-тай хамтран Монгол улсын нэгдсэн сурталчилгааны контент хийж гадаадад сурталчлах

-Аялал жуулчлалын тухай хууль болон дагалдах Мэргэжлийн хяналтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх

-Статистикийн тоо баримтад үндэслэн Улаанбаатар хотын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах

-Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын байгууллагын хандив зээл тусламжаар аялал жуулчлалын төсөл боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН: ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН БИЧСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ

